

**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМНЫ ДЭРГЭДЭХ
САЛБАР ЗӨВЛӨЛ**

**1 дүгээр хуралдаанаар хэлэлцсэн асуудлын тойм №1
2020.05.04**

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	“Салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн томилох тухай”	Төрийн албаны зөвлөлийн гишүүн С.Цэдэндамба Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 152 дугаар тогтоолыг танилцуулав. Салбар зөвлөлийн бүрэлдэхүүнд зөвлөмж өглөө.
2	Яамны албан хаагчдад Засгийн газрын 2020 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуралдааны 26 дугаар тэмдэглэлд “ Яамдын 2019 оны үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн дүнгээр Байгаль орчин, аялал жуулчлалын яам 3 дугаар байр эзэлсэнтэй холбогдуулан Эрхэлсэн, ахлах, дэс түшмэлийн зэрэг дэв шинээр олгох, ахиулах тухай болон яамны Ёс зүйн зөвлөлийн бүрэлдэхүүний тухай	Засгийн газрын 2020 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуралдааны 26 дугаар тэмдэглэлд “ Яамдын 2019 оны үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн дүнгээр Байгаль орчин, аялал жуулчлалын яам 3 дугаар байр эзэлсэнтэй холбогдуулан Эрхэлсэн түшмэлийн зэрэг дэв олгох саналыг Төрийн албаны зөвлөлд хүргүүлэх, албан хаагчдад ахлах, дэс түшмэлийн зэрэг дэв олгох, ахиулах тухай танилцуулга, яамны Ёс зүйн зөвлөлийн бүрэлдэхүүний талаарх саналыг хуралдаанд танилцуулахыг ТЗУГ /Л.Эрдэнэбулган/-т үүрэг болгов.
3	Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн “Хяналт, шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай” 29 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт /ЦУОГШГ/-ын хэрэгжилтийн өнөөгийн байдал, цаашид авах арга хэмжээний тухай	Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн “Хяналт, шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай” 29 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтын хэрэгжилтийг танилцуулахыг ЦУОШГ (С.Энхтүвшин)-т үүрэг болгов.
4	Яамны харьяа Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаа, Сав газрын захиргааны хүний нөөцийн тогтвортой байдал, цаашид авах арга хэмжээний тухай Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Усны газар байгуулсантай холбогдуулан хүний нөөцийн бодлого, төлөвлөлтийн тухай	Яамны харьяа Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаа, Сав газрын захиргааны хүний нөөцийн тогтвортой байдал, цаашид авах арга хэмжээний талаар санал боловсруулан салбар зөвлөлийн хуралдаанд танилцуулах. Холбогдох албан хаагчдад мэдэгдэх /Тусгай хамгаалалттай нутгийн удирдлагын газар /Э.Сансарбаяр/, Сав газрын удирдлагын хэлтэс /Н.Баттулга/, Усны газар шинээр байгуулсантай холбогдуулан хүний нөөцийн бодлого, төлөвлөлтийн талаар танилцуулахыг /Ш.Мягмар/-т тус тус даалгав.
5	Яамны албан хаагчдын ахлах, дэс, туслах түшмэлийн Албан тушаалын тодорхойлолтын тухай, 2020 оны ээлжийн амралтын тухай	Яамны албан хаагчдын 2020 оны ээлжийн амралтын хуваарь, Албан тушаалын тодорхойлолтыг 2020 оны 05 дугаар сарын 05-ны дотор Салбар зөвлөлийн даргад танилцуулахыг ТЗУГ /Л.Эрдэнэбулган/-т үүрэг болгов.

Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн анхдугаар хурал 2020 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн өглөөний 9 цагаас 301 тоот өрөөнд болов.